

□

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 20

Төрийн ордон, Улаанбаатар хот

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНЭЭР ТОМИЛОХ, ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Жамсранжавын Болд, Даваанямын Даваа-Очир, Пүрвээгийн Дэлгэрнаран, Эрдэнийн Түвшинжаргал нарыг томилсугай.
2. Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сайннямбуугийн Баатаржав, Эрдэнэбилэгийн Батболд нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс, Чойнзонгийн Содномцэрэнг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас, Цэдэн-Ишийн Болдсайханыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.
3. Энэ тогтоолыг 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР